САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

АРАВДУГААР 2018

ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ДНБ
6.4%
2018 оны III-р улирлын байдлаар

ИНФЛЯЦИ
6.3%

ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ
2564.14 төг

ТӨСВИЙН АЛДАГДАЛ
342 тэрбум төг

ГАДААД ХУДАЛДАА
1069 сая АМ.ДОЛЛАР

ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3.4 ТЭРБУМ ДОЛЛАР

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
11.9%

НИЙТ ХАДГАЛАМЖ
12 ИХ НАЯД ТӨГ

МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
27.9 САЯ АМ.ДОЛЛАР

ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
887 ТЭРБУМ ТӨГ

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
11%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +3.8%, 2019 онд: +4.3%
Инфляци: 2018 онд:+8%, 2019 онд +7%
Урсгал тэнцэл: 2018 онд ДНБ-ий -6.3%, 2019 онд: -7%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2018 оны тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: https://bit.ly/2HJFlip

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +5%, 2019 онд: +6.3%
Инфляци: 2018 онд: +6.4%, 2019 онд: +6.8%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2018 онд: -6.4%, 2019 онд: -8.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2018 он 4-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: http://bit.ly/2zsmvYo

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

АРАВДУГААР 2018

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 10-р сарын байдлаар 342 тэрбумын ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 28.9 хувиар, зарлага 10.3 хувиар тус тус өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 342 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 1 дахин буурсан байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 60 төгрөгөөр нэмэгдэв.

Аравдуаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 105 төгрөг буюу 4.3 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 60 төгрөг буюу 2.4 хувиар нэмэгдэж 2564.14 төгрөг болов. 10-р сард гадаад валютын нөөц 3.4 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 18 хувиар нэмэгдсэн байна.



Инфляцийн түвшин 6.3%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2018 оны 10-р сарын байдлаар өмнөх сараас 1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар, оны эхнээс 6.3 хувь өсөв. Тус сард ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, түлш, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ өсөхөд нөлөөлжээ.

Гадаад худалдааны тэнцэл 1069 сая.ам доллар болов.

2018 оны аравдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 10,820 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 24.1 хувиар өссөн бол экспорт 14.5 хувиар нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 38 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 1069 сая ам.долларын ашигтай гарлаа.



10-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: www.1212.mn

Нийт хадгаламж 2018 оны 10-р сард 12.1 их наяд төгрөг болж өмнөх сараас 47.8 тэрбум төгрөг буюу 0.7 хувиар буурав. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 19.7 хувиар буюу 2003 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 9442 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 0.7 хувиар буурсан бол валютын хадгаламж 2731.9 тэрбум төгрөг болж өмнөх сараас 0.8 хувиар өсчээ. Үүнээс төгрөгийн хадгаламж 78 хувь, валютын хадгаламж 22 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 22.9 хувиар буурсан бол валютын хадгаламж 9.8 хувийг эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ: Төвийн бүсийн өрсөлдөх чадварын чуулган-2018, зээлжих зэрэглэл тогтворжив.

- Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс 4 дэх жилдээ **"ТӨВИЙН БҮСИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ЧУУЛГАН 2018- ӨНӨӨДРИЙН ШИЙДВЭР, ИРЭЭДҮЙН ХӨГЖИЛ"** арга хэмжээг 2018 оны 10-р сарын 26-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан хотод зохион байгуулав. Дархан-Уул, Төв, Сэлэнгэ, Говь-Сүмбэр аймгууд өрсөлдөх чадварын үзүүлэлтэд тулгуурлан урт хугацаанд бодлогын түвшинд хамтран ажиллах боломж, хөгжлийн төсөл хөтөлбөрийн уялдааг сайжруулах талаар төр, хувийн хэвшлийн төлөөллүүд хэлэлцэв. Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааг 2012 оноос хийж эхэлсэн бөгөөд эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын болон бизнесийн үр ашиг, дэд бүтэц гэсэн үндсэн дөрвөн бүлэгт ангилан 180 гаруй үзүүлэлтээр хэмждэг. Зүүн бүсийн аймгуудын өрсөлдөх чадварын чуулган 2015 онд Сүхбаатар аймагт болж байсан бол Говийн бүсийнх Дундговь, Хангайн бүсийнх Хөвсгөл аймагт тус тус болж байв. Сүүлийн зургаан жилийн хугацаанд Орхон, Дархан-Уул, Өмнөговь зэрэг аймгуудын өрсөлдөх чадварын оноо тогтвортой хэвээр. Эдгээр аймаг өөрсдийн эрэмбээ ч хадгалсаар байна.

- Олон Улсын зээлжих зэрэглэл тогтоогч Стандарт энд Пүүрс (S&P Global Ratings) агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B- тогтвортой" төлвөөс "B тогтвортой" болгон нэмэгдүүлэв. Зээлжих зэрэглэлийг нэмэхэд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах бодлого нь эдийн засгийг хурдтай өсөхөд нөлөөлсөн, эдийн засгийн өсөлт 2018 оны эхний хагас жилийн байдлаар 6.3 хувьд хүрсэн нь бусад ижил түвшний зээлжих зэрэглэлийн үнэлгээтэй улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт болжээ.

Эх сурвалж:

1. *Статистикийн бюллетень, 10-р сар 2018 он, Үндэсний статистикийн хороо*
2. *Статистикийн бюллетень, 10-р сар 2018 он, Монголбанк*
3. *www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn,*